

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Тариалан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/82/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)  
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ  
Утас: 99900662 Цахим хаяг: [baterdenee@audit.gov.mn](mailto:baterdenee@audit.gov.mn)  
Аудитор: С.Гансүх  
Утас: 95908400 [gansvkhsa@audit.gov.com](mailto:gansvkhsa@audit.gov.com)  
Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн  
Захирал: Ахлах аудитор: Б.Мядагмаа  
Утас: 99389208 Цахим хаяг: [ikhermurun.audit@gmail.com](mailto:ikhermurun.audit@gmail.com)  
Аудитор: Д.Оюундаваа  
Утас: 99389692 Цахим хаяг: [oyundavaa9692@gmail.com](mailto:oyundavaa9692@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4-10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14-15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	14

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ГБХЗГ	Гэр бүл хүүхэд залуучуудын газар



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/204  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН  
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ЦЭЦЭГДЭЛГЭР  
ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Тариалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Тариалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



1720090001-3: 9070605

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>78,123,037.75</u></b>	<b><u>95,223,257.75</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>		
33300	Татаас, санхүүжилтийн авлага	457,140.00	237,516.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>		
3351	Байгууллагаас авах авлага	150,000.00	00.00
		307,140.00	237,516.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b><u>77,665,897.75</u></b>	<b><u>94,985,741.75</u></b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>		
35130	Эм боох материал	297,200.00	1,517,188.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>		
35410	Бичиг хэргийн материал	297,200.00	1,517,188.00
35420	Аж ахуйн материал	77,368,697.75	93,468,553.75
35450	Барилгын засварын материал	398,400.00	1,250,000.00
35460	Хүнсний материал	59,940,252.75	70,732,812.75
		2,492,450.00	402,600.00
		2,741,730.00	9,287,276.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,966,261,741.24</u></b>	<b><u>1,929,924,213.52</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>		
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,966,261,741.24	1,929,924,213.52
39202	Хуримтлагдсан элэгдэл	1,952,707,741.24	1,916,370,213.52
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,978,827,265.00	1,978,827,265.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-81,626,096.89	-135,156,271.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	54,281,486.00	73,065,284.08
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-19,790,565.27	-23,686,166.44
39208	Хуримтлагдсан элэгдэл	24,545,738.25	21,692,890.75
39214	Бусад үндсэн хөрөнгө	-8,522,133.05	-3,364,835.74
39215	Хуримтлагдсан элэгдэл	10,610,700.00	9,600,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-10,610,700.00	-9,600,000.00
39217	Ном	4,992,047.20	4,992,047.20
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>		
39303	Бусад биет бус хөрөнгө	13,554,000.00	13,554,000.00
		13,554,000.00	13,554,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,044,384,778.99</u></b>	<b><u>2,025,147,471.27</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,044,384,778.99</u></b>	<b><u>2,025,147,471.27</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b><u>2,044,384,778.99</u></b>	<b><u>2,025,147,471.27</u></b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,044,384,778.99	2,025,147,471.27
51101	Өмч: - төрийн	170,651,573.67	170,651,573.67
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		
51210	Өмнөх үеийн үр дүн	1,475,448,999.15	1,456,211,691.43
51220	Тайлант үеийн үр дүн	1,475,448,999.15	1,475,448,999.15
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	-19,237,307.72
		398,284,206.17	398,284,206.17
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,044,384,778.99</u></b>	<b><u>2,025,147,471.27</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,216,528,580.00</b>	<b>677,353,953.58</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,554,267,680.00</b>	<b>7,092,720.58</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,554,267,680.00</b>	<b>7,092,720.58</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,554,267,680.00	7,092,720.58
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,554,267,680.00	7,092,720.58
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>120,859,000.00</b>	<b>123,396,433.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	541,401,900.00	546,864,800.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>150,000.00</b>	<b>686,333.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	150,000.00	686,333.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>120,709,000.00</b>	<b>122,710,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	120,709,000.00	122,710,100.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>715,173,604.19</b>	<b>696,591,261.30</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>715,173,604.19</b>	<b>696,591,261.30</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>686,640,337.19</b>	<b>684,909,780.30</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>365,695,116.00</b>	<b>396,926,743.00</b>
210101	Үндсэн цалин	309,380,816.00	275,884,828.00
210102	Нэмэгдэл	28,233,200.00	92,960,915.00
210104	Урамшуулал	28,081,100.00	28,081,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>48,315,183.00</b>	<b>53,770,400.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	32,561,054.00	37,973,826.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,944,474.00	3,982,430.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,189,817.00	3,190,539.00
210204	Ажилгүйдлийн даатгал	749,804.00	781,642.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,870,034.00	7,841,963.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>117,981,700.00</b>	<b>119,182,800.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,800,000.00	4,200,000.00
210302	Түлш, халаалт	112,681,700.00	112,982,800.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	2,000,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>42,706,071.12</b>	<b>7,673,250.00</b>
210401	Бичиг хэрэг	336,500.00	491,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500,000.00	585,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,538,650.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,116,360.00	5,095,850.00
210408	Бараа материал акталсны зардал	28,714,561.12	00.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>38,639,990.00</b>	<b>29,479,387.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,107,800.00	947,833.00
210502	Хоол, хүнс	36,532,190.00	28,531,554.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,626,100.00</b>	<b>5,642,550.00</b>
210604	Урсгал засвар	8,626,100.00	5,642,550.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>370,000.00</b>	<b>286,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	370,000.00	286,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>550,000.00</b>	<b>1,081,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	250,000.00	781,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>63,756,177.07</b>	<b>70,867,650.30</b>

**Хөвсгөл аймгийн Тариалан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,353,079.68	464,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,805,700.00	4,958,102.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	58,597,397.39	65,444,748.30
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>28,533,267.00</b>	<b>11,681,481.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	360,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	360,000.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,173,267.00	11,681,481.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,173,267.00	11,681,481.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,501,354,975.81</b>	<b>-19,237,307.72</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,501,354,975.81</b>	<b>-19,237,307.72</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	170,651,573.67	398,284,206.17	1,475,448,999.15	2,044,384,778.99
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	170,651,573.67	398,284,206.17	1,475,448,999.15	2,044,384,778.99
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	170,651,573.67	398,284,206.17	1,475,448,999.15	2,044,384,778.99
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-19,237,307.72	-19,237,307.72
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	170,651,573.67	398,284,206.17	1,456,211,691.43	2,025,147,471.27

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>366,773,700.00</b>	<b>670,411,233.00</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	150,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	150,000.00
120009	Бусад орлого	00.00	150,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>366,773,700.00</b>	<b>670,261,233.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	300,773,700.00	546,864,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	686,333.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	686,333.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	66,000,000.00	122,710,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	66,000,000.00	122,710,100.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>321,172,464.00</b>	<b>645,341,233.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	321,172,464.00	645,341,233.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	321,172,464.00	633,659,752.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,535,885.00	396,857,119.00
210101	Үндсэн цалин	178,259,235.00	275,018,900.00
210102	Нэмэгдэл	14,172,300.00	93,757,219.00
210104	Урамшуулал	17,104,350.00	28,081,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,296,130.00	53,770,400.00
210201	Тэтгэврийн даатгал	12,235,779.00	37,838,400.00

Хөвсгөл аймгийн Тариалан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	1,271,410.00	3,983,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,077,401.00	3,186,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	181,365.00	796,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,530,175.00	7,966,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>64,816,534.00</b>	<b>119,182,800.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,066,534.00	4,200,000.00
210302	Түлш, халаалт	63,000,000.00	112,982,800.00
210303	Цэвэр, бохир ус	750,000.00	2,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,288,715.00</b>	<b>11,466,233.00</b>
210401	Бичиг хэрэг	120,000.00	674,200.00
210402	Тээвэр, шатахуун	364,200.00	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	190,515.00	585,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,800,000.00	436,333.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,814,000.00	8,269,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>11,965,200.00</b>	<b>37,212,100.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	790,500.00	195,000.00
210502	Хоол, хүнс	4,179,300.00	35,077,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,995,400.00	1,940,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,270,000.00</b>	<b>5,727,300.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,270,000.00	00.00
210602	Тавилга	00.00	2,200,000.00
210604	Урсгал засвар	00.00	3,527,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>00.00</b>	<b>286,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	00.00	286,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>00.00</b>	<b>1,081,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	781,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	300,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>00.00</b>	<b>8,076,800.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	464,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	7,612,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>00.00</b>	<b>11,681,481.00</b>
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>11,681,481.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	11,681,481.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>45,601,236.00</b>	<b>25,070,000.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>3,730,000.00</b>	<b>25,070,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,730,000.00</b>	<b>25,070,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>3,730,000.00</b>	<b>25,070,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,730,000.00	25,070,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-3,730,000.00</b>	<b>-25,070,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>				
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	669,574,900.00	657,893,419.00	11,681,481.00	98.26
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	669,574,900.00	657,893,419.00	11,681,481.00	98.26
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	398,298,700.00	396,857,119.00	1,441,581.00	99.64
210101	Үндсэн цалин	275,018,900.00	275,018,900.00	00.00	100.00
210102	Нэмэгдэл	95,198,800.00	93,757,219.00	1,441,581.00	98.49
210104	Урамшуулал	28,081,000.00	28,081,000.00	00.00	100.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	53,770,400.00	53,770,400.00	00.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	37,838,400.00	37,838,400.00	00.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,983,000.00	3,983,000.00	00.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,186,400.00	3,186,400.00	00.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	796,600.00	796,600.00	00.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,966,000.00	7,966,000.00	00.00	100.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	119,182,800.00	119,182,800.00	00.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	4,200,000.00	4,200,000.00	00.00	100.00
210302	Түлш, халаалт	112,982,800.00	112,982,800.00	00.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	2,000,000.00	00.00	100.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,399,900.00	11,399,900.00	00.00	100.00
210401	Бичиг хэрэг	585,900.00	674,200.00	-88,300.00	115.07
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,500,000.00	00.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	585,900.00	585,900.00	00.00	100.00
210404	Ном, хэвлэл	88,300.00	00.00	88,300.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,639,800.00	8,639,800.00	00.00	100.00
2105	<b>Нормативт зардал</b>	47,449,800.00	37,212,100.00	10,237,700.00	78.42
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	195,300.00	195,000.00	300.00	99.85
210502	Хоол, хүнс	45,301,500.00	35,077,100.00	10,224,400.00	77.43
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,953,000.00	1,940,000.00	13,000.00	99.33
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	30,027,300.00	30,027,300.00	00.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,500,000.00	20,500,000.00	00.00	100.00
210602	Тавилга	6,000,000.00	6,000,000.00	00.00	100.00
210604	Урсгал засвар	3,527,300.00	3,527,300.00	00.00	100.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	288,200.00	286,000.00	2,200.00	99.24
210702	Дотоод албан томилолт	288,200.00	286,000.00	2,200.00	99.24
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,081,000.00	1,081,000.00	00.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	781,000.00	781,000.00	00.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00	00.00	100.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	807,680.00	807,680.00	00.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	464,800.00	464,800.00	00.00	100.00

Хөвсгөл аймгийн Тариалан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,612,000.00	7,612,000.00	00.00	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	669,574,900.00	657,893,419.00	11,681,481.00	98.26
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	546,864,800.00	535,183,319.00	11,681,481.00	97.86
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	546,864,800.00	535,183,319.00	11,681,481.00	97.86
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	122,710,100.00	122,710,100.00	00.00	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	122,710,100.00	122,710,100.00	00.00	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	36.00	36.00	00.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	23.00	23.00	00.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00	00.00	100.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>836,333.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	836,333.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	836,333.00
2104	Хангамж, бараа материалын зардал	836,333.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	436,333.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	400,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>836,333.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	836,333.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	836,333.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Тариалан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд е-баримтын бүрдэлтэй холбоотой, хоолны нормативт зардалтай холбоотой зөвлөмжүүд тусгасан болно.

Аудитыг Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Мядагмаа, аудиторын туслах Ж.Уранчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг, аудитор Ц.Мөнхтуяа хэрэгжүүлж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Гансүх, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ нар анхан шатанд, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Тариалан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 07 тоот албан бичгээр Ихэрмөрөн-Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Хөвсгөл аймгийн Тариалан сумын хүүхдийн цэцэрлэг нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагаа явуулж байна.

2021 онд багш, сурагч, эцэг эхийн хамтын ажиллагаанд тулгуурласан хосолсон сургалтын хэлбэрийг нэвтрүүлэн, хичээл, сургалтын үйл ажиллагаанд бие даан суралцах арга зүйг хэрэгжүүлж, хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг дэмжин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд: Нийгмийн даатгалын тухай хуульд заасан шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орж, Монгол Улсын засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 43-р тогтоол, “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг шинэчлэх тухай” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал батлагдаж гарсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Тариалан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 715.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 14.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 11.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Тариалан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан загвараар бэлтгэсэн байна.

2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19.2 сая төгрөгөөр буюу 0.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая. төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0.4	0.2	-0.2
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	77.5	93.5	16.0
Үндсэн хөрөнгө	1,966.2	1,929.9	-36.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,044.4</b>	<b>2,025.1</b>	<b>-19.3</b>
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,044.4	2,025.1	-19.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,044.4</b>	<b>2,025.1</b>	<b>-19.3</b>

Тайлант хугацаанд ажиллагасадтай холбоотой 0.2 сая төгрөгийн авлага буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 93.5 сая төгрөг болж 16.0 сая төгрөгөөр буюу 20.6 хувиар өссөн байгаа нь дараах хөдөлгөөнүүд нөлөөлсөн байна. Үүнд:

- Байгууллагын хэвийн үйл ажиллагааг явуулахад зориулж төсвийн хөрөнгөөр нийт 61.4 сая төгрөгийн бараа материалын худалдан авалт хийсэн байна.
- Иргэдээс 3.0 сая төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн, аж ахуй хангамжийн материал үнэ төлбөргүй ирсэнийг тус тус орлогоор хүлээн авч байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулж 47.3 сая төгрөгийн бараа материалыг тус тус зарцуулж ажилласан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 1,929.9 сая төгрөг болж 36.3 сая төгрөгөөр буюу 1.8 хувиар буурсан байгаа нь дараах ажил гүйлгээ нөлөөлсөн байна. Үүнд:

- Боловсролын яамны хөрөнгө оруулалтаар 4.1 сая төгрөгийн 7 нэр төрлийн компьютер принтер, тавилга эд хөрөнгүүд нийлүүлэгдсэн байна.
- Хөвсгөл аймгийн Тариалан сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн №28 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй 28 нэр төрлийн 84 ширхэг 14.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан.
- Тайлант хугацаанд 55.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал зэрэг тус тус нөлөөлсөн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Хөвсгөл аймгийн Тариалан сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 01 дүгээр тогтоолоор тус цэцэрлэгийн төсвийг 753.1 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн явцад Хөвсгөл аймгийн ИТХ-ийн 2021 оны 08 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дугаар тогтоолоор тодотгол хийж, тусгай зориулалтын шилжүүлгээс 569.3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 122.7 сая төгрөгөөр төсвийн нийт зарлага 692.1 сая төгрөгөөр баталж 61.0 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Төсвийн жилийн явцад Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/608 дугаар захирамжаар зохицуулалт хийж, тус байгууллагын анхны батлагдсан төсвийг 83.5 сая төгрөгөөр бууруулснаар төсвийн зарлага 669.6 сая төгрөг болжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсролын 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 669.6 сая төгрөгийн санхүүжилт авч, Үүнээс тусгай зориулалтын шилжүүлгээс 546.8 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 122.7 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 657.9 сая төгрөгийг зарцуулж, 11.7 сая төгрөгийг төвлөрүүлж ажилласан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэлийг анхны батлагдсан төсөвтэй харьцуулахад 657.8 сая төгрөг буюу 98.3 хувьтай байгаа нь ковид-19 цар тахлын улмаас 190 хоног хичээллэхээс 95 хоног хичээллэж нормативт зардал, байр ашиглалт, үндсэн цалинтай холбоотой тогтмол зардал дутуу зарцуулагдсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт төсвийн дансаар нийт 0.8 сая төгрөгийн орлогыг дараах зориулалтаар хүлээн авсан.

- Хөвсгөл аймгийн Боловсролын газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/40 тоот тушаалаар, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбоотой анги танхимын ариутгал халдваргүйжүүлэлт хийх зориулалтар 0.4 сая төгрөгийн орлого авсан;
- Хөвсгөл аймгийн ГБХЗГазраас зохиогдсон тэмцээнд амжилтай оролцож 0.2 сая төгрөгийн шагналын мөнгө ирсэн.
- Хөвсгөл аймгийн ЗДТГазраас шагналд ирсэн, 2020 оны зарцуулагдаагүй үлдсэн 0.1 сая төгрөгийн орлогууд тус тус ирсэн.

Нэмэлт төсвийн дансанд хүлээн авсан орлогын зарцуулалтын эрхийг Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн журамд заасан баримтын бүрдлийг ханган НТ№1 маягтаар төрийн санд хүргүүлж эрх нээлгэж зориулалтын дагуу ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж ажилласан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхдээ Монгол Улсын ерөнхий аудиторын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу төсвийн хэмнэлтийн бодлого, зарцуулалт, шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилт, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад асуудалд анхаарлаа хандуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлтийг гаргаж ажилласан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Хөвсгөл аймгийн Тариалан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад АОУС 701.8-д тодорхойлсон үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын ерөнхий аудиторын “Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх ерөнхий чиглэл батлах тухай” 2021 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан чиглэлийн дагуу шилэн дансны мэдээллийг шалгахад 1,370.2 сая төгрөгийн 85 мэдээллийг ил тод байршуулахаас, 1,3707.2 сая төгрөгийн 83 мэдээллийг ил тод байршуулж, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байдлын хэрэгжилт 98.0 хувьтай байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Худалдан авах ажиллагааны тухайд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгөгдөж, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 101.4 сая төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 33.7 сая төгрөгийн 4 алдааг залруулж, 67.7 сая төгрөгийн 2 зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өглөө.

### **4.1 Залруулсан алдаа**

Аудитын явцад санхүүгийн тайлагналтай холбоотой 33.7 сая төгрөгийн 4 алдааг аудитын хугацаанд залруулсан. Үүнд:

1. Өмчийн өөрчлөлтийн тайлангийн тайлант үеийн үр дүн 8.6 сая төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.үнэн зөв байх; гэсэн заалтад нийцэхгүй байгаа тул аудитын хугацаанд залруулж ажилласан.
2. Үндсэн хөрөнгийн тодруулгын, элэгдлийн зардал 10.8 сая төгрөгийн зөрүүтэй толилуулсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.үнэн зөв байх; гэсэн заалттай нийцэхгүй тул аудитын хугацаанд залруулсан .
3. Үндсэн хөрөнгийн тодруулгын акталсан болон дахин үнэлсэн хөрөнгийн дүн 14.2 сая төгрөгийн алдаатай толилуулгыг аудитын хугацаанд залруулсан.
4. Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн талаар төсвийн гүйцэтгэлийн тайланийн танилцуулга бэлтгэж хавсаргаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 54.5.Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна: гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа тул аудитын хугацаанд залруулсан.

### **4.2 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт өгөгдөөгүй болно.

### **4.3 Албан шаардлага**

Албан шаардлага гараагүй болно.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Анхан шатны баримт е-баримтаар нотлогдсон эсэх

1.1 Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн зарлагын 63.3 сая төгрөгийн гүйлгээ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.4.доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх гэсэн заалтад нийцэхгүй байна. “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.4.доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

##### 2. Хүүхдийн хоолны норматив зардал

2.1 Илрүүлэлт: Хүүхдийн хоолны зардлыг шалгахад, нэг хүүхдэд ногдох норматив зардлыг 4.4 сая төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан нь хоолны зардлын норматив тогтоох тухай Засгийн газрын 2019 оны №450 дугаар тогтоолын 1 дэх заалтад нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2019 оны №450 дугаар тогтоолын 1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөвсгөл аймгийн Тариалан сумын хүүхдийн цэцэрлэг	6	101.4	4	33.7	-	-	-	-	1	67.7

#### БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК

ХЯНАСАН: АУДИТОР

БОЛОВСРУУЛСАН: АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР Огноо:

Э.БАТ-ЭРДЭНЭ Огноо:

С.ГАНСҮХ Огноо: 25/5

Ц.МӨНХТУЯА Огноо:

Б.МЯДАГМАА Огноо:

